



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/37

Хэрлэн сум

**Комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн Арван наймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөрхаан тохижилтын газарт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын  
дарга:

Б.Мөнхжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга:

Н.Баярсайхан

Өндөрхаан тохижилтын газрын Ногоон байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Б.Тэмүүлэн

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Хотын арихтектор, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Н.Наранцэцэг

Өндөрхаан тохижилтын газрын Нярав

Ц.Хатанболд

Өндөрхаан тохижилтын газрын Хог хаягдлын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА

